



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3, 3.2.6 дахь заалт, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний 3.4.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хотын аяллын хөтөч, тайлбарлагч нарт зориулсан “Музейд тайлбар хийх ур чадвар” сэдэвт сургалт, семинар зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургалтын төсөв болох 440.000 /дөрвөн зуун дөчин мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

3. Сургалт, семинарыг удирдамжид заасан хугацаанд зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн /Ш.Ундармаа/, дотоодын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн /Н.Алтанзаяа/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
 даргын 2014 оны 03 сарын 11 өдрийн
 А/16 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



**“МУЗЕЙД ТАЙЛБАР ХИЙХ УР ЧАДВАР”
 СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

Зорилго: Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг музей, үзвэрийн газарт тайлбар, танилцуулга хийж буй хөтөч-тайлбарлагч, орчуулагч нарын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд сургалтын зорилго оршино.

Сургалтын хөтөлбөр:

№	Сэдэв	Заах багш	Байр ба хугацаа
2014 оны 03 дугаар сарын 29-ний өдөр			
1	Нээлт	Э.Баттулга (Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга)	Монголын Үндэсний Музейд 9:00 – 9:05
2	-Улаанбаатар хотын музей үзвэрийн газрууд нь хотын аяллын чухал бүрэлдэхүүн болох нь -Аялал жуулчлалд музейн гүйцэтгэх үүрэг	Ч.Буянбадрах (Олон улсын аялал жуулчлалын хөгжлийн төв) урилгаар	Монголын Үндэсний Музейд 9:05 – 10:00
3	Монголын Үндэсний Музейн түүх, үзмэрийн онцлог, брэнд үзмэрийн тухай танилцуулга	Тус музейн ажилтан	Монголын Үндэсний Музейд 10:00 – 11:30
4	Музейн тайлбар хийх ур чадвар	Буянбадрах (Олон улсын аялал жуулчлалын хөгжлийн төв) урилгаар	Монголын Үндэсний Музейд 12:00 – 13:00
Завсарлага /Цайны цаг/			13:00-13:30
5	Цэргийн түүхийн музейн түүх, үзмэрийн онцлог, брэнд үзмэрийн тухай танилцуулга	Тус музейн ажилтан	Цэргийн музейд 13:30 – 15:30
6	УБ хотын музейн түүх, үзмэрийн онцлог, брэнд үзмэрийн тухай танилцуулга	Тус музейн ажилтан	УБ хотын музейд 15:30 – 17:30
2014 оны 03 дугаар сарын 30-ны өдөр			
7	Богд хааны ордон музейн түүх, үзмэрийн онцлог, брэнд	Тус музейн ажилтан	Богд хааны ордон музейд

	үзмэрийн тухай танилцуулга		9:00-11:30
	Завсарлага /Цайны цаг/		11:30-12:00
8	Чойжин ламын сүм музейн түүх, үзмэрийн онцлог, брэнд үзмэрийн тухай танилцуулга	Тус музейн ажилтан	Чойжин ламын сүм музейд 12.00-14:30
9	Оюун ухааны музейн түүх, үзмэрийн онцлог, брэнд үзмэрийн тухай танилцуулга	Тус музейн ажилтан	14:30-16:30
2014 оны 03 дугаар сарын 31-ний өдөр			
10	Нийслэл дэх түүхэн хөшөө дурсгал, барилга байгууламжийн тайлбар	А.Цэрэнчулуун	9:00-10:30
11	Нийслэлийн түүх	А.Цэрэнчулуун	10:30-12:00
	Завсарлага /Цайны цаг/		12:00-12:30
12	Орчуулга хийхэд анхаарах зүйлс, туршлага	А.Цэрэнчулуун	12:30-13:30
	Гэрчилгээ гардуулах ёслол		13:30-14:00

Хамрах хүрээ: Аялал жуулчлалын хөтөч тайлбарлагч нар хамрагдана.

Зохион байгуулагч: Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Олон улсын аялал жуулчлалын хөгжлийн төв

Хугацаа: 2014 оны 3-р сарын 29, 30, 31-ний Бямба, Ням, Даваа гарагт зохион байгуулна.

Хүрэх үр дүн: Улаанбаатар хотын аялал жуулчлалын үзмэр, үзвэрийн газруудыг тайлбарлах хөтөч-тайлбарлагч нарын ур чадвар сайжирснаар хотын аяллын бүтээгдэхүүнийг сонирхох жуулчдын сонирхол, үнэлэмж дээшилнэ.

Хаана болох: Монголын Үндэсний Музей, Цэргийн музей, Улаанбаатар хотын музей, Богд хааны ордон музей, Чойжин ламын сүм музей, Оюун ухааны музей, нийслэлийн Аялал жуулчлалын газрын Мэдээлэл, сурталчилгааны төв

Бүртгэх газар: Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дэргэдэх Аялал жуулчлалын мэдээлэл, сурталчилгааны төв (Бага тойруу-15 Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Нийслэлийн Засаг захиргааны 4-р байр хуучнаар Улаанбаатар банкны байрны Баруун хойд талын хаалга) Холбоо барих утас: 70108687, 7012-8687, 99838674, 91666064

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын
2014 оны 03 сарын 11-ний өдрийн 4/16 тоот
тушаалын хоёрдугаар хавсралт



“МУЗЕЙД ТАЙЛБАР ХИЙХ УР ЧАДВАР”
СУРГАЛТЫН ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Автобусны зардал	2	120,000	240,000
2	Гэрчилгээ хэвлүүлэх	100	1000	100,000
3	Цэвэр ус /баллонтой/	10	2500	25000
4	Багшийн цагийн хөлс	5 цаг	15.000	75000
	Нийт дүн			440,000

ТӨСӨВ ЗОХИОСОН:
НАЖГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

Ш.УНДАРМАА

ХЯНАСАН:
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

П.АРИУНАА